



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 491

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.7, 57.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа (жилээр, сараар)	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бodoх хувь
2 дахь жил (13 – 24 сар)	1
3 дахь жил (25 – 36 сар)	2
4 дэх жил (37 – 48 сар)	3
5 дахь жил (49 – 60 сар)	4
6 дахь жил (61 – 72 сар)	5
7 дахь жил (73 – 84 сар)	6
8 дахь жил (85 – 96 сар)	7
9 дэх жил (97 – 108 сар)	8
10 дахь жил (109 – 120 сар)	9
11 дэх жил (121 – 132 сар)	10
12 дахь жил (133 – 144 сар)	11
13 дахь жил (145 – 156 сар)	12
14 дэх жил (157 – 168 сар)	13
15 дахь жил (169 – 180 сар)	14
16 дахь жил (181 – 192 сар)	15
17 дахь жил (193 – 204 сар)	16
18 дахь жил (205 – 216 сар)	17
19 дэх жил (217 – 228 сар)	18
20 дахь жил (229 – 240 сар)	19
21 дэх жил (241 – 252 сар)	20
22 дахь жил (253 – 264 сар)	21
23 дахь жил (265 – 276 сар)	22
24 дэх жил (277 – 288 сар)	23
25 дахь жил (289 – 300 сар)	24
26 ба түүнээс дээш жил (301 ба түүнээс дээш сар)	25

2. Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Т.АЮУРСАЙХАН